

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих Хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ эх үүсвэр /сая төгрөг/	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/		Хэрэгжилтийн хувь
						2020 / 2021 он		
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
2.2 Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.								
22.	2.2.1 Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.	1.	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021-2024	-	-	Засгийн газрын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хороонд төсөл боловруулах ажил хийгдэж байна.	0%
23	Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.	2.	Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна.	2021-2024	-	%	Биеийн тамир, спортын тухай хуулийн 17.1 дэх заалтад заасны дагуу Үндэсний спортын наадам 4 жилд 1 удаа өвөл, зуны төрлөөр 2022 онд зохион байгуулагдана.	-

24.	2.2.3 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.	3.	Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна.	2021-2024	Улсын төсөв	Хэрэгжилт ийн хувь	“Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, эх загвар зураг (эскиз)-ийг боловсруулах ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар хамтран гүйцэтгэж байна. “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах төслийн концепц, загвар зураг төсөл боловсруулах уралдааныг зарлан, сонгон шалгаруулалтыг хийж “Хаус дизайн” ХХК-ны боловсруулсан “Хийморь цогцолбор” бүтээл шалгарсан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршуулан 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон. Барилгын ажил хийгдэж эхлээгүй байна.	30%
25.		4.	Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна.	2022-2024	Улсын төсөв	2022 оноос хэрэгжүүлж эхэлнэ.	Биеийн тамир, спортын Улсын хорооноос Боловсрол, шинжлэх ухааны сайдтай зөвшилцөн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулах саналыг хэлэлцэж байна.	-
26.		5.	Нийслэлийн болон Налайх, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэжлүүлэн ашиглалтад оруулна.	2021-2024	Улсын төсөв /42290.2 сая төгрөг/	Хэрэгжилт ийн хувь	2010-2020 оны хооронд Нийслэл болон Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Налайх, Сүхбаатар дүүргүүдийн спорт цогцолборуудын 6 барилгын явц дунджаар 75%-ийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны улсын төсөвт 2.4 тэрбум төгрөг тусгагдаж барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор 2020 оны 6-р сард ашиглалтад орсон.	70%

						<p>-Баянгол дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 9005,4 сая төгрөг, өмнөх онуудад нийт 5002.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 2020 онд 2.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын 95%-ийг "Молор Констракшн" ХХК;</p> <p>-Баянзүрх дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 8229.3 сая төгрөг, өмнөх онуудад нийт 731.5 сая төгрөгийн санхүүжилт авч, барилгын ажлын 90%-ийг "Атимос трейд" ХХК;</p> <p>-Налайх дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 10397.9 сая төгрөг, барилгын ажлын 95%-ийг "БҮРД констракшн" ХХК;</p> <p>-Сүхбаатар дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 7377.4 сая төгрөг, өмнөх онуудад 2800.0 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэгч компани барилгын ажлын 30%-ийг хийж гүйцэтгэсэн. 2020 оны төсөвт 200.0 сая төгрөгийн санхүүжилт авч, барилгын ажлын 40%-ийг "Грейн ресурс" ХХК;</p> <p>-Нийслэлийн спорт цогцолборын нийт өртөг 7280.2 сая төгрөг, өмнөх онуудад 3257.0 сая төгрөгийн санхүүжилт авч, барилгын ажлын 30%-ийг "Үүрэг трейд" ХХК зэрэг гүйцэтгэгч компаниуд тус тус гүйцэтгэсэн.</p> <p>2020 оны улсын төсөвт Нийслэл, Баянзүрх, Налайх дүүргүүдийн спорт цогцолборын шаардлагатай санхүүжилт суугдаагүй.</p>		
27.		8.	Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зургаг төсөл	2021-2024	Азийн хөгжлийн банкнаас санхүүжилт /10,856.4	Хэрэгжилтийн хувь	Дэд төвүүдэд Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд: Сонгинохайрхан дүүргийн 40-р хороо, Баянхошуу дэд төв 650 хүний суудалтай спорт цогцолбор, Сүхбаатар дүүргийн 17-р хороо, Дамбадаржаа дэд төв 400 хүний суудалтай спорт	30%

			боловсруулах ажлыг зохион байгуулна.		1/		цогцолбор, Баянзүрх дүүргийн 24 хороо 400 хүний суудалтай спорт цогцолборуудыг нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг хөтөлбөрт тусгуулаад байна. Спортын барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах талаар холбогдох байгууллагуудтай уулзалт зөвлөгөөн зохион байгуулсан.	
НИЙТ:								32,5 %

ХЯНАСАН:
ДАРГА

Ж.ГАНБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
СПОРТЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНТУЯА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГАДААД ХАРИЛЦАА, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ТАЙЛАН МЭДЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ӨЛЗИЙЖАРГАЛ